



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ  
ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН  
ШИЙДВЭР**

2024 06 05  
оны сарын өдөр

182/ШШ2024/02538  
Дугаар

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС**

Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Энхтуяа даргалж, тус шүүхийн шүүх хуралдааны танхимд хийсэн иргэний хэргийн шүүх хуралдаанаар,

Хүсэлт гаргагч: Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Сүхбаатарын талбай-3, өөрийн байр. Монголын хөрөнгийн бирж ХК /2071096/-ийн хүсэлттэй,

Хүсэлтийн шаардлага: Хариуцагчаар оролцвол зохих этгээд болох Асе энд Т капитал ҮЦК ХХК, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийг эрэн сурвалжлуулах тухай хэргийг хянан хэлэлцэв.

Шүүх хуралдааны оролцогчид:

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Б.Ануужин,

Хүсэлт гаргагчийн төлөөлөгч П.Ундрах-Эрдэнийн хүсэлтээр түүний эзгүйд хэргийг хянан шийдвэрлэсэн болно.

**ТОДОРХОЙЛОХ нь:**

1. Монголын хөрөнгийн бирж ХК, түүний төлөөлөгч шүүхэд гаргасан хүсэлтдээ: Асе энд Т капитал ҮЦК ХХК нь Монголын хөрөнгийн бирж ХК-иар 2004 оноос үнэт цаасны арилжаагаа гүйцэтгүүлж эхэлсэн. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3-т зааснаар Монголын хөрөнгийн бирж ХК нь үйлчилгээний хөлс болон урамшууллыг тогтоох эрхтэй байгууллага бөгөөд үнэт цаасны бүртгэлийн журам батлан дагаж мөрдүүлж, үйлчилгээний хөлсөө тогтоосон. Мөн Асе энд Т капитал ҮЦК ХХК нь Монголын хөрөнгийн бирж ХК-тай 2008.04.28-ны өдөр хамтран ажиллах гэрээ байгуулсан. Гэрээний 2.4.5-т гишүүн нь "гишүүний жилийн хураамжийг холбогдох журамд заасны дагуу улирлаар төлөх ба төлбөрийг улирал бүрийн эхний 10 хоногт, утасны төлбөрийг дараа сарын 20-ны дотор багтаан тус тус төлөх" үүрэгтэй. Гэвч Асе энд Т капитал ҮЦК ХХК нь төлбөл зохих төлбөрөө цаг тухайд нь төлөх үүргээ биелүүлэлгүй өнөөдрийг хүрсэн тул шүүхээр шийдвэрлүүлэхээс өөр аргагүй байдалд хүрсэн. Улмаар Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан ч 2024.04.08-ны өдрийн 181/Ш32024/07338 дугаар шүүгчийн захирамжаар хаяг тодорхойгүй үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон. Хариуцагчийн хаяг тодорхойгүй, одоо ямар хаягт байгаа нь мэдэгдэхгүй байх тул хариуцагчаар оролцвол зохих этгээд болох Асе энд Т капитал ҮЦК ХХК, төлөөлөх эрх бүхий этгээдийг эрэн сурвалжилж, хаягийг тодорхойлж өгнө үү гэжээ.

2. Хүсэлт гаргагч нь Монголын хөрөнгийн бирж ХК-ийн дүрэм, 2008.04.28-ны өдрийн хамтран ажиллах гэрээ, 2010.06.21, 2011.03.09-ний өдрүүдийн нэр өөрчлөхийг зөвшөөрөх тухай Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаал,

**24002250**



2006.01.02-ны өдрийн гишүүнээр элсүүлж, суудлын эрх олгох тухай Монголын хөрөнгийн бирж ХК-ийн гүйцэтгэх захирлын тушаал, үнэт цаасны бүртгэлийн журам, 2012.02.17-ны өдрийн журамд нэмэлт өөрчлөлт оруулах, 2018.01.25-ны өдрийн журмыг шинэчлэн батлах, 2014.06.30-ны өдрийн журам батлах тухай Монголын хөрөнгийн бирж ХК-ийн ТУЗ-ийн тогтоол, 2014.06.30, 2018.01.25-ны өдрийн Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн бүртгэлийн журам, нэхэмжлэх, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024.04.08-ны өдрийн 181/Ш32024/07338 дугаар хэргийг хэрэгсэхгүй болгох тухай шүүгчийн захирамж зэрэг баримтуудыг шүүхэд гарган өгсөн байна.

#### ҮНДЭСЛЭХ нь:

1. Монголын хөрөнгийн бирж ХК нь хариуцагчаар оролцвол зохих этгээд болох Асе энд Т капитал ҮЦК ХХК, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийг эрэн сурвалжлуулах тухай хүсэлт гаргаж байх бөгөөд уг хүсэлтийнхээ үндэслэлийг Асе энд Т капитал ҮЦК ХХК нь хамтран ажиллах гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй, гишүүний хураамжийг төлөөгүй, манай байгууллагад өртэй, хаана байгаа нь мэдэгдэхгүй байна гэж тайлбарлажээ.

Хүсэлт гаргагчийн тайлбар, Монголын хөрөнгийн бирж ХК-ийн дүрэм, 2008.04.28-ны өдрийн хамтран ажиллах гэрээ, 2010.06.21-ний өдөр, 2011.03.09-ний өдрүүдийн нэр өөрчлөхийг зөвшөөрөх тухай Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаал, 2006.01.02-ны өдрийн гишүүнээр элсүүлж, суудлын эрх олгох тухай Монголын хөрөнгийн бирж ХК-ийн гүйцэтгэх захирлын тушаал, үнэт цаасны бүртгэлийн журам, 2012.02.17-ны өдрийн журамд нэмэлт өөрчлөлт оруулах, 2018.01.25-ны өдрийн журмыг шинэчлэн батлах, 2014.06.30-ны өдрийн журам батлах тухай Монголын хөрөнгийн бирж ХК-ийн ТУЗ-ийн тогтоол, 2014.06.30, 2018.01.25-ны өдрийн Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн бүртгэлийн журам, нэхэмжлэх зэрэг баримтуудаар Асе энд Т капитал ҮЦК ХХК нь хариуцагчаар оролцвол зохих этгээд байна.

2. Хариуцагчаар оролцвол зохих этгээд болох Асе энд Т капитал ҮЦК ХХК нь Сүхбаатар дүүргийн 5 дугаар хороо, Сөүлийн гудамж-37, Смарт бюлдинг, 301 тоотод оршин байрладаггүй, түүнчлэн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нээлттэй мэдээлэлд тэмдэглэгдсэн Сүхбаатар дүүргийн 2 дугаар хороо, 303-305 гэх хаяг нь тус хороонд байдаггүй, хаана байгаа нь тодорхойгүй болох нь хүсэлт гаргагчийн тайлбар, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024.04.08-ны өдрийн 181/Ш32024/07338 дугаар хэргийг хэрэгсэхгүй болгох тухай шүүгчийн захирамж, шүүхийн ажиллагааны баримт буюу шүүхэд дуудан ирүүлэх тухай шүүхийн мэдэгдэх хуудас, Засаг даргын тодорхойлолтоор тогтоогдсон.

Иймд хариуцагчаар оролцвол зохих этгээд болох Асе энд Т капитал ҮЦК ХХК нь хаана байгаа нь тодорхойгүй, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 155 дугаар зүйлийн 155.1-д заасан үндэслэл бүрдсэн байх тул Монголын хөрөнгийн бирж ХК-ийн гаргасан хүсэлтийг хангаж, Асе энд Т капитал ҮЦК ХХК, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд болох Н.Мянганбаярыг эрэн сурвалжлах үндэслэлтэй гэж үзэв.

3. Хүсэлт гаргагч Монголын хөрөнгийн бирж ХК-ийн тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 төгрөгийг улсын төсөвт хэвээр үлдээх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1., 60 дугаар зүйлийн 60.1., Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7.1.2-т заасантай нийцнэ.



Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.2, 115.2.1, 133 дугаар зүйлийн 133.1.9-д заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 155 дугаар зүйлийн 155.3-т зааснаар Асе энд Т капитал ҮЦК ХХК /5003164/, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд болох Норовын Мянганбаярыг эрэн сурвалжилсугай.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 155 дугаар зүйлийн 155.4-т зааснаар Асе энд Т капитал ҮЦК ХХК-ийн үйл ажиллагаа явуулж байгаа болон түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд болох Н.Мянганбаярын оршин суугаа хаягийг тогтоох ажиллагааг хийж, энэ тухай хүсэлт гаргагчийн төлөөлөгч П.Ундрах-Эрдэнэ /99014719, 88691739/-д мэдэгдэхийг Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газарт даалгасугай.

3.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 60 дугаар зүйлийн 60.1-д зааснаар хүсэлт гаргагч Монголын хөрөнгийн бирж ХК-ийн тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 төгрөгийг улсын төсөвт хэвээр үлдээсүгэй.

4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5, 120 дугаар зүйлийн 120.2-т зааснаар шийдвэрийг зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч гардан авсан эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болохыг дурдсугай.

5.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.2, 119.3, 119.4, 119.7-д зааснаар шийдвэр танилцуулан сонсгомгоц хүчинтэй болж, 14 хоногийн дотор бичгээр гарах ба, шүүх хуралдаанд оролцсон тал уг хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор шүүхэд хүрэлцэн ирж шийдвэрийг өөрөө гардан авах үүрэгтэй, энэхүү үүргээ биелүүлээгүй нь давж заалдах гомдол гаргах хугацааг хуульд заасан журмын дагуу тоолоход саад болохгүйг дурдсугай.

ДАРГАЛАГЧ



Т.ЭНХТУЯА